



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-22

1.“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2025.05.19-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/	4-22
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
05 дугаар сарын 23-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 02 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Б.Батбаатар, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Б.Жаргалан, Н.Номтойбаяр, Б.Энхбаяр, Л.Энхнасан, Р.Эрдэнэбүрэн.

Нэг. “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2025.05.19-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга А.Хишигбаяр, мөн газрын ахлах шинжээч Б.Мөнхбаяр, Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Д.Билгүүдэй нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр, Д.Энхтүвшин, Э.Болормаа, Н.Наранбаатар, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан хариулж, тайлбар хийв.

Г.Тэмүүлэн: “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт гарын үсэг зурахыг эрхийг олгоё гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай, Д.Энхтүвшин, С.Эрдэнэболд нарыг дэмжсэнээр тооцож,

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 11 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 58 минут үргэлжилж, 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их засаг” танхим 10 цаг 02 минут

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе ээ.

Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна. Ирцийг та бүхэнд танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн, Очирбатын Амгаланбаатар гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Нанзадын Наранбаатар гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн хүрэлцэн ирснээр 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал нэг асуудал байгаа.

Засгийн газраас яаралтай горимоор энэ 5 сарын 19-ний өдөр буюу энэ 7 хоногт өргөн мэдүүлсэн зөвшилцөхөөр оруулж ирж байгаа. Хоёр улсын Засгийн газар хоорондын зөвшилцөх нэг асуудал байгаа. Энэ Нийгэм хамгааллын тухай Монгол Улс болон БНАУ хоорондын хэлэлцээрийн төслийг өргөн мэдүүлсэн байна аа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё. Ажлын хэсгийг оруулаарай. Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд танилцуулна аа.

Таныг микрофон дээр урьж байна. Дараа нь ажлын хэсгийг танилцуулъя.

Л.Энх-Амгалан: Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар гадаад улсад ажиллаж амьдарч буй Монгол иргэдийн нийгмийн баталгааг хангах зорилгоор тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж ирсний нэг нь Монгол Улсын иргэд олноор оршин суудаг улстай нийгмийн хамгааллын хэлэлцээрийг байгуулж, 2 улсын иргэдийн нийгмийн харилцаанд харилцан тэгш эрхтэй байх, тухайн улсын иргэний нэгэн адилаар тэтгэвэр тэтгэмж авах хууль эрх зүйн үндсийг бүрдүүлж ирлээ.

Одоогийн байдлаар ОХУ, БНСУ, Унгар улс бүгд Бүгд найрамдах Польш Улс БНТУ, БНЧУ гэсэн 6 улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр байгуулан хэрэгжүүлж байна аа. Түүнчлэн Бүгд Найрамдах Австри, Бүгд

Найрамдах Казахстан улс, Австралийн Холбооны улстай шинээр хэлэлцээр байгуулах, ОХУ-тай байгуулсан хэлэлцээрийг шинэчлэхээр ажиллаж байна аа. Олон улсын гэрээний дагуу хуулийн холбогдох заалтуудын дагуу БНАУ-ын талтай Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон БНАУ хоорондын хэлэлцээрийн төслийг эцэслэн тохирсноор хэлэлцээрийн төслийг Монгол Улсын Засгийн газар 2025 оны 5 сарын 7-ны өдрийн Засгийн газар хуралдаанаар дэмжиж Улсын Их Хурлын Аюулгүй байдал, байнгын хороонд зөвшилцөхөөр хүргүүлсэн болно оо.

Энэхүү хэлэлцээр нь нийгмийн даатгалын хуулиудад зааснаар өөр журмаар тэтгэврийн эрх үүсгэх олгох харилцааг зохицуулсан тул олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-д зааснаар заавал соёрхон батлах олон улсын гэрээ юм. ГХЯ-ны 2024 оны мэдээллээр Австри Улсад Монгол Улсын 2668 иргэн оршин сууж байгаагаас 1696 иргэн ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол Гадаадын иргэн харьяатын 2024 оны мэдээллээр Монгол Улсад Австрийн 30 орчим иргэн оршин сууж амьдарч байна аа.

Уг хэлэлцээр батлагдаж хэрэгжсэнээр 2 улсын иргэд Монгол Улс болон БНАУ-д ажилласан жил шимтгэл давхцаагүй хугацаагаа нэгтгэн тооцуулж өндөр насны тэтгэвэр тогтоолгох 2 улсад даатгалын шимтгэл төлсөн хугацаанд ноогдох тэтгэврийг т тогтоолгон авах боломж бүрдэж нийгмийн баталгаа нь сайжрах юм аа.

Хэлэлцээрийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд хэлэлцээр батлагдсанаар бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй бөгөөд улсын болон нийгмийн даатгалын төсөвт нэмэлт хөрөнгийн эх үүсвэр шаардахгүй юм аа. Хэлэлцээрийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг Байнгын хорооны гишүүдээсээ хүсэж байна аа.

Г.Тэмүүлэн: Энх-Амгалан сайдад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдоод Засгийн газраас орж ирсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд Энх-Амгалан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал хуримтлалын сангийн бодлогын газрын дарга Рэнцэнханд, НДЕГ-ын дарга Батжаргал, мөн яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга Хишигбаяр, яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Билгүүдэй, яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын ахлах шинжээч Мөнхбаяр гэсэн бүрэлдэхүүнтэйгээр оролцож байна аа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хэлэлцээрийн төслийн талаар асуулттай гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя.

Болормаа гишүүнээр тасалъя. Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Нэг Монгол хүнийг бүтээх гэж насанд хүргэх гэж бид Монголчууд бид татвар төлөгчид, Монголчууд нэлээн л их хөрөнгө мөнгө цаг хугацаа зарцуулдаг. Тэгээд яг ингээд насанд хүрэнгүүтээ ингээд гадагшаа явдаг. Мэдээж хүний эрхийн асуудал л даа. Гэхдээ ер нь ингээд гадаадад байгаа Монголчууд маань тэр улсад л ингээд баялаг бүтээж үлдээгээд байна л даа. Тэр улсыг л хөгжүүлээд байдаг. Гэтэл энэ эх орондоо өнөөдөр хувийн хэвшил нь боловсон хүчний хомсдолд орчихсон. Төр ч гэсэн боловсон хүчний хомсдолтой л

байх шиг байна. Тэгэхээр ер нь Монгол хүн Монголдоо ажиллах, амьдрах аятай тохитой орчныг бүрдүүлэх, нутагтаа эзэн байх, нутагтаа хангалттай цалин хөлс аваад энх тунх амьдрах энэ орчин нөхцөлийг бүрдүүлэх тал дээр мэдээж Монгол төр ажиллаж байна. Тэгээд ер нь цаашдаа ингээд гадаадад амьдрах ажиллах нөхцөлийг нь улам сайжруулаад гэх юм уу боломж гаргаж өгөөд энэ боломжийг ер нь илүү ингээд нээлттэй болгоод яваад байх нь ер нь яг том бодлогын хувьд хэр зохистой вэ? Ер нь тэгээд өнөөдөр энэ улсыг чинь Монголчууд л хөгжүүлнэ болохоос биш хувийн хэвшлийнхэн чинь ихэнх нь л Филиппинээс, Хятадаас, Энэтхэгээс ажилчин авна гээд л. Одоо энэ Хөдөлмөрийн яам руу ч гэсэн баахан хүсэлт өгөөд л хэдэн мянган хүний л ажлын байрны асуудал яриад л явж байгаа юм байна лээ. Тэгээд танайхаас ч гэсэн квот тогтоож өгөх юм байна лээ.

Тэгэхээр энэ дээр ер нь ямар бодлоготой байгаа вэ? Тэгээд мэдээж яах вэ нэгэнт гараад ажиллаж байгаа тэр хүмүүсийг би бол ойлгохдоо бүгд л яг хөдөлмөрийн насны ид хийж бүтээж байгаа Монголчууд л гадаадад ажиллаж байгаа гэж ойлгож байгаа. Түүнээс биш тэнд очоод нэг их амраад л, зугаалаад л, хэвтээд л аятай тохитой амьдраад байгаа хүн олон байгаа гэж харахгүй л байгаа л даа. Тэгэхээр ер нь тэр валютын ханшаа цаашдаа яаж тооцох юм? Үнэхээр яг тэр хүмүүс амьдралынхаа ид үедээ, тэр гадна ажиллачхаад, яг нэг тэтгэвэр аваад амарч, зугаалах насан дээрээ эргээд ирсэн чинь нөгөө нийгмийн даатгалын шимтгэл нь хэр бодит байдалтайгаа уялдаж нийцэж байх юм. Тэр үед валютын ханш ч гэдэг юм уу төгрөгийн ханштай хэр уялдах юм. Энэ тал дээр хийсэн судалгаа байна уу гэсэн ийм асуулт байна.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Хосбаяр гишүүнээ ер нь энэ яагаад Монголчууд гадагшаа нөгөө брэйн болоод байгаа яагаад брэинтэй болж чадахгүй байна тархи гадагшаа яагаад гоожоод байна гэдэг асуудал бол Монгол хүний нэг цагт бүтээж байгаа бүтээмж тэрний цалин хөлсний л асуудал юм билээ. Одоо ингээд Монгол залуучууд бол эх орондоо ажиллах хөдөлмөрлөх, амьдрах бүх хүсэл тэмүүлэл байгаа. Гэтэл харамсалтай нь өнөөдөр Монгол хүний нэг цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож үзэж байгаа шүү дээ. Нэг цагийн цалин хөлс бол доллар 10 цент л байгаа байхгүй юу. Доллар 10 цент. Тэгэхээр энэ нэг цагийн хөлс хамгийн багадаа нэг 5-аас 8 доллар болж байж хүмүүс эх орондоо ажиллах амьдрах ийм хүсэл тэмүүлэлтэй болдог юм байна лээ. Тэгээд энэ хийсэн тооцоо байдаг юм. Нийт н хүний ДНБ 12 мянгаас 17 мянган доллар болсон цагт бол ингээд гадагшлах ажиллах хүчний гадаадад ажиллах эх орноосоо дайжих энэ явдал зогсдогоо гэсэн энэ Европын холбооноос гаргасан ийм тооцоо байдаг юм байна лээ.

Тэгэхээр бид нар энэ Монгол Улсын Засгийн газар хэрэгжүүлж байгаа нэг хүнд ноогдож байгаа ДНБ-ийг нэг 10 мянган доллар болгох гээд байгаагийн цаад бодлого бол Монгол залуучууд Монголчууд эх орондоо ажил хөдөлмөр эрхлэх ийм хүсэл тэмүүллийг төрүүлэх ийм л бодлого байх юм л гэж би харж байгаа юм Хөдөлмөрийн сайдын хувьд. Тэгээд манайх нэг зүйлийг ерөөсөө хэмжиж үзээгүй юм байна. Юуг хэмжиж үзээгүй вэ гэхээр энэ ДНБ-д эзэлж байгаа энэ цалин хөлсний зардал гэж нэг ийм хэмжээс байдаг юм байна лээ. Тэгэхээр манай улс бол энэ ДНБ-д эзэлж байгаа цалин хөлсний зардал их багатай явдаг, багатай явдаг.

Тэгэхээр энийг бол ингээд бид нар ер нь цаашаа өсгөх ийм л асуудлуудыг шийдэж байж л энэ Монголчууд эх орондоо тогтвор суурьшилтай ажиллах ийм л

орчин бүрдэх ёстой юм байна гэж харж байгаа юм. Гэхдээ бид нар нэг зүйл дээр их сайн дүгнэлт хийх ёстой.

Яагаад өнөөдөр Монгол Улс ажиллах хүчний энэ хомсдол үүсчихсэн бэ гэдэг асуудал бол бүх Монголчууд гадагшаа гараад явчихсан асуудал биш шүү дээ Хосбаяр. Одоо нийт 213 мянган монголчууд гадаадад амьдарч байна ажиллаж байна. Тэгээд 1990-ээс 2004 оны хооронд нийт 14 жилийн хугацаанд одоо яг нөгөө бид нарын төрөлт багассан. Яг энэ үед уг нь төрөлт багасаагүй байсан бол энэ үед төрсөн хүүхдүүд өнөөдөр хөдөлмөрийн зах зээл дээр ажиллаж байх, хөдөлмөрийн зах зээлийн оролцоог хангаж байх ёстой ийм нийт 300-аас 350 мянган боломж алдагдсан боломж гэж нэрлэдэг юм уу энэ боломжоо алдсан. Энэ бол манай Монгол Улсад маш том цохилт болж байгаа. Юу гэхээр бид нар өнөөдөр яг ажиллах хүчний рүмүүс бол 1 2 сая хүрэхгүй нөөцтэй. Тэрэн дотор ажил хөдөлмөр эрхэлж байгаа нь 1.2 сая. 1.2 сая ажил хөдөлмөр хийж эрхэлж байгаа энэ хөдөлмөрийн зах зээл дээр байгаа Монголчуудад бол 550-аас 650 мянган хүний хомсдол үүсчихсэн байхгүй юу. 213 мянга нь гадаадад байна. Бага төрөлтийн үеэс 350-аас 380 мянган төрөх ёстой байсан хүүхдүүд төрж чадаагүй энэ боломжийг алдсан. Ингээд энэ бол манайд ажиллах хүчин хөдөлмөрийн зах зээл дээр бол хамгийн том хомсдол үүсгэсэн гол шалтгаан юм байгаа юм шүү.

Энийг Их Хурлын гишүүд та бид нар их зөв ойлгож зөв дүгнэлт хийж байж одоо яахгүй бол бодлогоо боловсруулахгүй бол ерөөсөө Монголчууд бүгдээрээ дайжаад ингээд явчихсан юм шиг байж болохгүй ээ. Энэ яг Монгол хүний нэг цагт бүтээж байгаа бүтээмж. Нэг цагт бүтээсэн бүтээмж дээр олгож байгаа цалин хөлстэй л холбоотой ийм асуудал юм байна лээ гэдгийг мэдээлэл болгож хэлье ээ.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүн нэмж тодруулъя.

Г.Хосбаяр: Нөгөө нэг тэр гадаадаас ажиллах хүч оруулж ирэх дээр танайхаас нэг бичиг сачиг хувийн хэвшлүүд баахан өгөөд л байгаа юм байна лээ. Тэгээд ер нь яг аль аль улсаас одоо миний олж сонссоноор бол Филиппин Вьетнам гээд л олон л улсын нэр дуулдаад байгаа. Энэ чинь нөгөө яг бодлоготойгоо хэр нийцэж байгаа вэ? Ер нь одоо яг энэ жил хэчнээн аль аль улсаас хэчнээн ажиллах хүчин ямар мэргэжлээр чиглэлээр оруулж ирэх юм бэ?

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүний нэмэлт асуултад хариулъя. Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Хосбаяр гишүүн их чухал асуудал хөндөж ярьж байна аа. Тэгээд бид нар нийгэмд их зөв ойлголт өгмөөр юм байна лээ. Юу гэхээр ингээд нэг ийм ажиллах хүчний квотыг хязгааргүй болгочихдог нэг ийм ойлголт байдаг манай Жемкагаас авхуулаад 280 мянган хужаа оруулж ирэх гэж байна энэ тэр гэдэг тийм зүйлийг ярьсан. 280 мянган хүнийг хэзээ ч Монгол Улс ерөөсөө 1 жилд авдаггүй. Ерөөсөө Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дээр байгаа хомсдолууд бол 30-аас 50 мянган ажиллах хүчний л хомсдол байдаг юм жилийн. 30-аас 50 мянга тэрийг л ингээд угаасаа зохицуулдаг ийм хуультай. Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хуультай. Ингээд энүүгээр бол нийт хүн амын нэг хувьд хүрэхгүй хязгаартай шүү дээ. Нэг хувьд хүрэхгүй тэр тусмаа нэг улсаас бол яг энэ квотын 30-аас дээшгүй хувийг эзлэхгүй байх гэсэн ийм бид нар хязгаартай юм байгаа юм.

Тэрнээс биш нөгөө нэг квотгүйгээр ингээд гаднаас ажиллах хүч оруулж ирдэг нэг ийм тогтолцоотой улс орон биш.

Г.Тэмүүлэн: Энх-Амгалан сайд энэ жил мега төсөл хэрэгжих томоохон төсөл хэрэгжүүлэх энэ хүрээнд бол Засгийн газар шийдвэр гаргаж нөгөө 100 хувь ажлын байрны юунаас чөлөөлдөг, төлбөрөөс чөлөөлдөг. Тодорхой салбаруудтай. Улс орны алсын хараа дунд болон урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулж хэрэгжиж байгаа одоо энэ төсөл хөтөлбөрүүд дээр бол чөлөөлдөг. Энэ жил бид нар нэг 28 мянга орчим гаднаас ажиллах хүч оруулах ийм юутай байгаа, хэрэгцээ байгаа. Өнөөдрийн байдлаар Засгийн газраас өгсөн зөвшөөрлөөр чөлөөлсөн чөлөөлөхөөр бол нийт нэг 20 орчим мянган ажиллах хүчин гаднаас авах ийм л зөвшөөрлүүд олгогдож байгаа.

Тэгээд ер нь одоо энэ ажиллах хүчний зөвшөөрлийг бид нар нэлээн их тийм юу олгож байгаа шүү дээ. Хүнд сурталгүй, чирэгдэлгүй зарим зарим салбарууд дээр бол ямар ч байсан энэ квотдоо багтаагаад ажиллах хүчнээ оруулж ирэх энэ зөвшөөрөл бол олгогдож байгаа.

Г.Тэмүүлэн: Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Саяхан их хурал дээр энэ Казакстантай хийх гэж байгаа хэлэлцээрийн гэрээ байна хэлэлцээр байна. Тэгээд Австритай хийж байгаа гэрээний төсөл. Тэгээд харьцуулаад харахаар яах вэ зөрөөтэй юмнууд их байгаад байгаа. Одоо нэг стандарт ч юм уу гэрээний бүтэц нэр томьёо нэрээсээ авхуулаад нэлээн зөрөөтэй харагдаад байгаа.

Өөрөөр хэлбэл юу гэсэн үг гэхээр нөгөө талаасаа тавьсан саналыг голдуу хүлээж авч байна уу? Одоо яг хэлэлцээрийн түвшин нь ямар явж байна? Зарим нэг жишээлбэл хэрвээ манай талд давамгайл оролцдог байсан зарим нэг юмыг нь стандарт ч юм уу, ижил болгочихоор юмнууд харагдаад байна лээ л дээ. Тэгэхээр яах вэ зүгээр ингээд сүүлийн үед Улсын Их Хуралд орж ирж байгаа гэрээнүүдийг харахаар ялангуяа гадаад улсуудтай хийж байгаа гэрээн дээр Монголын тал гэхээсээ илүү нөгөө талынхаа тавьсан саналыг л хүлээж авч байгаа юм шиг иймэрхүү дүр зургууд харагдаад байгаа. Сая Хятадтай хийсэн гэрээ, Оростой хийх гэж байгаа гэрээний төслүүдийг харж ирэхээр үг үсгийн хувьд найруулгын хувьд ч гэсэн тэр манай тал бараг хэлэлцээрт оролцоогүй, хэлэлцээгүй юм шиг иймэрхүү дүр зургууд харагдаад байна лээ л дээ. Тэгэхээр яг энэ Австритай хийх гэж байгаа энэ нэг хэлэлцээрийн төсөл дээр манай талаас ямаршуу оролцоотой ажилласан юм бэ? Ер нь цаашдаа энэ олон улсын энэ хэлэлцээрүүд дээр ямаршуу жишиг стандарт барьдаг юм. Гэхдээ Гадаад хэргийн яам энд илүү хариулах ёстой юу гээд ийм 2 асуулт байна.

Г.Тэмүүлэн: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Энхтүвшин гишүүн ээ одоо энэ нийгмийн хамгааллын гэрээг бол ер нь улс орнууд хийх их сонирхол багатай байдаг юм байна лээ. Тэр тусмаа өнөөдөр ингээд нөгөө гаднаас ажиллах хүчин авч ажиллуулж байгаа Солонгос гэдэг юм уу Европын Холбооны Улс, АНУ, Япон улсууд хэлэлцээрт их суух дургүй. Тэгээд одоо бид нар бол яг үнэхээр бол энэ хэлэлцээрийг хийх Монголчуудынхаа эрх ашгийг хамгаалахын төлөө бол яг өнөөдөр Монголчууд хамгийн их ажил хөдөлмөр эрхэлж байгаа Солонгос, Япон, АНУ сүүлд Австрали 13, 14 мянга л болж байна.

Тэгэхээр ингээд энэ улсуудтай бол хэлэлцээр хийх гэж нэлээн их хүсэлтүүдийг тавьдаг. Тэгээд жишээ нь өнөөдөр гэхэд Австри улстай хийж байгаа гэрээн дээр бол Австри улсад амьдарч байгаа бид нар чинь Монголчуудынхаа эрх ашгийг бол 2600 иргэдийнхээ эрх ашгийг бид нар хамгаалж байгаа.

Эргээд Монголд байгаа Австри Улсын иргэдэд гучхан иргэдийн л асуудал хөндөгдөж байгаа байхгүй юу. Тийм учраас бол бид нар бол илүү энэ хийж байгаа нийгмийн хамгааллын гэрээнүүд бол Монголчуудынхаа эрх ашгийг хамгаалах энэ чиглэл рүү хийгддэг ийм гэрээ юм байгаа юм. 1 дүгээрт.

Хоёрдугаарт бол энэ гэрээний хүрээнд нөгөө өчигдөр бас Бейсен гишүүн асуугаад байсан. Энэ чинь ерөөсөө зөвхөн тэтгэврийн, нийгмийн даатгалын харилцаа гэж зохицуулж байгаа гэрээнүүд хийгдэж байгаа байхгүй юу. Тэгэхэд энэ хүрээнд зарим улсууд бол нөгөө ЭМД-ыг хөнддөг, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалыг хөнддөг. Ажилгүйдлийн даатгалыг хөнддөг учраас бол энэ асуудлууд нь тухайн улс орондоо нэлээн зардалтай эрх зүйн зохицуулалтууд байдаг учраас бол аль болохоор тийм гэрээ байгуулахаас цааргалдаг. Одоо жишээ нь энэ яах вэ нээлттэй хурал байх шиг байна. Зарим улсууд дээр бол манайхыг нэлээн тулгаж байгаа. Гэрээгээ зурах асуудал дээр ч гэсэн тулгаж байгаа ийм улс орнууд байгаа шүү дээ, хөрш ордуудаас авхуулаад.

Тэгэхээр энэ дээр бид нар бас нэлээн Монголынхоо талд Монголынхоо нийгмийн даатгалын сан дээр ачаалал багатай байх илүү гадаадад ажиллаж амьдарч байгаа Монголчуудынхаа эрх ашгийг хамгаалах чиглэл рүү ингэж хэрэгжиж байгаа гэрээнүүд их олон жилийн хэлэлцээрүүд байдаг юм байна лээ. Олон жил хэлэлцээр хийж байж энэ нөгөө тохиролцоонд хүрдэг. Тийм учраас бол илүү өнөөдрийн 6 улстай өнөөдрийн байдлаар 6 улстай энэ хэлэлцээрүүдийг хийсэн байна. Энэ 6 улстай хийсэн хэлэлцээрийн үр дүнд илүү Монголчууд илүү их үр ашгийг нь хүртдэг ийм л нийгмийн хамгааллын гэрээ юм байгаа юм. Тэгээд ГХЯ яах вэ зуучлах үүрэгтэй. Гол хэлэлцээрийн нөхцөлүүд бол манай яам голчилж оролцдог. Яах вэ зүгээр нөгөө хамгийн гол асуудал бол нөгөө олон тэтгэврийн даатгалын, нийгмийн даатгалын сантай холбоотой хэлэлцээрээс гадна энэ тэтгэврийн нөгөө тогтолцоо нь өөр улсуудад их зовлонтой байдаг юм. Одоо жишээ нь Австри нөгөө Казахстан энэ тэр улсууд бол хагас хуримтлалаас бүрэн хуримтлалын тогтолцоонд орчихсон улсууд бол илүү нөгөө гадагшаа бусдуудтайгаа төлсөн НДШ-ийг гадагшаа төлөх тийм сонирхол их багатай байдаг юм байна лээ.

Тэгэхээр энэ гэрээ бол гадаадад амьдарч байгаа Монголчуудын эрх ашгийг хамгаалж байгаа иргэд маань эргээд эх орондоо ирээд ингээд амьдрахад урт удаан хугацаанд амьдрахад тэр мотивац болсон түшиг болсон ийм л гэрээний зарчмууд явагддаг юм гэдгийг би хэлье.

Г.Тэмүүлэн: Тодруулах уу? Болормаа гишүүн асуулт асууя.

Э.Болормаа: Ингээд яаралтайгаар айлчлалтай холбоотойгоор энэ гэрээ орж ирж байна гэж ойлгож байна. Тэгээд бас цаашид ч гэсэн эдгээр асуудлуудыг илүү цаг хугацаа өгсөн байдлаар оруулж ирвэл зүйтэй байна. Өнөөдөр чуулганы хуралдаан ч гэсэн энэ яг асуудлаас болж хойшлогдож байна гэж ойлгож байгаа. Оруулж ирж байгаа Энх-Амгалан сайдаас асуух гэсэн юм. Яг энэ хэлэлцээрийг би их энгийн үгээр ойлгоход Австрид ажиллаж амьдарч байгаа манай Монгол иргэд мөн манай Монгол Улсад ажиллаж амьдарч байгаа Австри иргэдийн нийгмийн

хамгааллын энэ аль аль улс орны тухайн хуулийнх нь дагуу олгох энийг бий болгож байгаа. Энэ дээр ямар нэгэн эдийн засгийн тооцоолол байна уу гэдгийг ажлын хэсгээс асууя. Одоо юу гэдэг юм Австрид ажиллаж байгаа Монгол хүн жишээлбэл тэнд нийгмийн даатгалаа төлөөд эргээд Монголдоо ирэхэд тэтгэвэр авах гээд байна уу? Яг энийг нэг маш бодитойгоор энгийнээр нэг ойлгуулаад өгөөч. Эргээд нөгөө талдаа энэ танилцуулга дээр байгаагаар бол 31 Австри иргэн Монголд оршин сууж байгаа юм байна. Эдгээрээс яах юм бэ?

Тэгэхээр яг өнөөдрийн нөхцөл байдал дээр энэ тодорхой эдийн засгийн тооцооллыг хэлээд өгөөч гэж хүсье.

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүний асуултад хариулъя. Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Ийм байгаа юм Болормаа гишүүн ээ. Энэ өнөөдрийн соёрхон баталж байгаа энэ гэрээгээр одоо жишээ нь Монголдоо 15 жил ажиллаж байгаад Австри Улсад Монголдоо 15 жил ажиллаад НДШ-ээ төлсөн иргэн Австри улсад очоод 13 жил ажиллаад тэндээ НДШ-ээ төлсөн хугацаа нь бүрдсэн тохиолдолд бол 28 жилээр тооцогдож тэтгэврээ тогтоолгох ийм эрх л үүсэж байгаа юм. 28 жилээр. Австридаа тийм. Тэгэхээр Австри улс чинь жил бүхэн 6 сараар тэтгэврийнхээ насыг өсгөж явж байгаа шүү дээ. Манайх бол жил бүхэн 3 сараар. Тэгэхдээ дөнгөж одоо нийгмийн даатгалын албан журмын даатгал төлж байгаа хүмүүсийн дөнгөж 53 хувь нь л 3 сараар өсөж байгаа шүү дээ. Бусад нь дандаа хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэрт гарч байгаа. Удахгүй бид нар Улсын Их Хурал дээр энэ тэтгэврийн шинэчлэл тогтолцооны асуудлуудаар эрх зүйн актуудаа хуулиудаа өргөн барина. Энэ хүрээнд бол нэлээн энэ тэтгэвэр тогтоолгох нас ажилласан жил, шимтгэлтэй холбоотой асуудлуудыг бид нар хөндөнө өө. Энэ бол илүү Австрид ажиллаж байгаа Монголчуудынхаа эрх ашгийг хамгаалах энэ чиглэл рүү хийгдэж байгаа ийм л гэрээ юм байгаа юм.

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүн нэмж тодруулъя.

Э.Болормаа: Тэгэхээр эдгээр Австрид ажиллаж байгаад магадгүй эргээд Монгол Улсдаа ирэхэд эдгээр хүмүүсийн тэтгэвэр нь тогтоолгоход яах вэ? Жишээлбэл нөгөө Австрид төлсөн тэтгэврийнхээ хэмжээг нь мөн жилийг нь тооцоод тэгээд Монгол Улсдаа тэтгэврийн хэмжээгээр тооцоолно гэж ойлгож байгаа зөв үү? Тэгээд ер нь энэ 1670 иргэн нийт 2577 иргэн оршин сууж байгаагаас 1670 гэдэг нь одоо яг хууль ёсны дагуу бүгд нийгмийн даатгалаа тэнд Австрид төлж байгаа иргэд үү? Яг хэдэн хүнд бид нар хамаарах юм батлах гээд соёрхон батлах гэж байгаа вэ гэдгийг тодруулах гэсэн юм.

Г.Тэмүүлэн: Энх-Амгалан сайд хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Та яг зөв хэлж байна. Яг одоо Австри улсад Монгол Улсаас 2668 иргэн оршиж байгаагаас ажил хөдөлмөр эрхэлж байгаа буюу НДШ-ээ төлж байгаа 1696 иргэн байгаа юм байна лээ. Энэ иргэдтэй хамаатай асуудлууд. Энэ иргэд маань буцаж ирээд Монгол Улсдаа тэтгэврээ үргэлжлүүлж авах хэрэв тэтгэвэрт гарчихсан бол Монгол Улсдаа тэтгэврээ үргэлжлүүлж авах, хэрэв гараагүй бол тэнд ажиллаж байгаад Австри улсад 20 жил ажиллаад буцаад Монгол Улсдаа өмнө нь ажиллаж байгаад тэгээд энд ирээд үргэлжлүүлээд ингээд албан журмынхныхаа нийгмийн даатгалыг төлөөд явсан тохиолдолд бол үргэлжлээд

Монгол Улсдаа тэтгэврээ авах тэтгэврээ тогтоолгох энэ эрх нь үүсэж байгаа ийм л гэрээ юм байгаа юм.

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүн нэмж тодруулъя.

Э.Болормаа: Та сая нөгөө 6 улс орон дээр энийг хийх гэж байгаа гэсэн. Тэр иргэдийнхээ бол эрх ашгийг хамгаалж байгаа юм байна. Нөгөө талаараа боол гадаадад ажиллаж амьдарч байхдаа НДШ-ээ сайн дураараа төлдөг олон иргэд байдаг. Тэгэхээр нийгмийн даатгалын шимтгэлээ сайн дураараа төлөх шаардлагагүй болно гэж ойлгож байгаа.

Тийм учир энэ бас нийгмийн даатгалын сангийн бүрдүүлэлт нь нэг их өндөр хэмжээгээр биш ч гэсэн тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа гэж ойлгож байна. Цаашид бас манай Аюулгүй байдлын байнгын хороо эдгээр соёрхон батлах ийм гэрээнүүдийг дандаа бас төсөв санхүүгийн нөлөөллийг нь шаардаж баймаар байна. Тэгэхгүй бол бид нар ингээд нөгөө хууль баталдаг, соёрхон баталж байгаа энэ олон улсын гэрээ гэдэг чинь яг л Монгол Улсын хуультай дүйцэхүйц тийм зүйл учир сая миний асуугаад байсан асуултууд бусад ер нь ийм гэрээн дээр ч гэсэн төсөв санхүүгийн нөлөөллийг нь тооцоолж байж тэгээд дараа нь бид нар нөгөө төсөв ярих гэсэн чинь энэ хуулиа баталчихсан шүү дээ гэдэг юм ярих ёстой учир энийг ажлын албанаас анхаараач гэж хүсье.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Байнгын хорооны гишүүдэд энэ өглөөний мэнд хүргэе ээ. Түрүүн сайд хэлж байсан ажиллах хүчний хомсдол гээд ярьж байсан. Ажиллах хүчин чинь бол энэ төрийн алба тэгээд энэ ТӨК-уд дээр байгаа юм байна лээ шүү. Саяхан Дэлгэрсайхан сайд бид 2 Зүүнбаянгийн төмөр зам, Тавантолгой, Гашуун сухайтын төмөр зам гээд 2 төмөр зам дээр очиход л ер нь 800-аас мянган хүнтэй тус бүрдээ байна лээ. Яг тийм хэмжээний хувийн төмөр зам дээр 200 хүн ажиллаж байх жишээтэй. Тэгэхээр хувийн ААН хийж байгаа ажлыг төрийн өмчит компани 4-өөс 5 дахин их хүнээр хийж байгаа юм байна лээ шүү. Тэгээд цалин авсан. Тэгээд ажилгүй ингээд баахан хүмүүс чинь энэ ТӨК-уд дээр шигдчихсэн. Энэ төрийн албанд чинь шигдчихсэн ийм байдалтай байгаа юм байна лээ.

Тийм учраас ажиллах хүчний хомсдол гэж ярихаасаа илүү ажиллах хүчнийхээ зохицуулалт ийг зөв хийх ёстой юм байна лээ. Асуулт нь энэ шууд хэлэлцэж байгаа асуудалтай холбоогүй ч гэсэн яамныхан байгаа учраас тэгээд надаас сонгогчид асуугаад байгаа учраас асуучихъя. Өнгөрсөн жил энэ Тэмүүлэн гишүүн бид нар хамтраад Малчны тухай хууль баталсан юм.

Тэгээд энэ малчны тухай хуульд НДШ-ийг нэг удаа нөхөж төлүүлэх боломж олгоно гээд оруулчихсан үүнийг асуугаад байгаа. Журам батлагдана гэсэн хариу өгсөн. Журам нь хэзээ батлагдах юм. Одоо яг тов тодорхой хэлээдэхье. Журам нь батлагдах юм уу үгүй юм уу. Энэ заалт ер нь цаашдаа хэрэгжих юм уу үгүй юм уу. Хэрэгжихгүй бол яамнаас Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хойшлуулдаг биш хойшлуулдаг юм уу аль эсвэл буцаагаад нэмэлт, өөрчлөлт оруулаад авч хаядаг юм уу. Нэг тийш нь болгохгүй нэг баахан малчдад хүлээлт үүсгэчихсэн.

Хоёрт гэвэл малчдыг ипотекийн зээлд хамруулна гээд орчихсон. Малчны нэг хүүхдийг нь төрийн өмчийн их дээд сургуульд сургана гээд төрийн зардлаар гээд

орчихсон. Нэг ийм хууль батлагдаад 1 сарын 1-ээс эхлээд хэрэгжихээд байхад газар дээрээ ингээд хэрэгжүүлэх ёстой газрууд нь яамдууд нь хэрэгжүүлэхгүй юм. Тэгээд үүнийг их асуугаад байгаа юм. Та бүхэн нэг товч тодорхой хариулт өгөөдхөөч.

Г.Тэмүүлэн: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Монгол Улсын Засгийн газар хууль хэрэгжүүлэх ёстой, хуулиа дээдэлж ажиллах ёстой. Энэ Малчдын тухай хууль батлагдаж гарсан нэлээн олон эдийн засгийн үр дагавартай ийм хууль юм байна лээ. Тэгээд яах вэ энэ хуулийг хэрэгжүүлэхэд Засгийн газраас журам батлах ёстой юм Наранбаатар гишүүн ээ. Тэгээд энэ журмыг батлахад одоо яг энэ хуульд хамрагдах хэдэн малчин байх вэ, бид нар ямар нөхцөлд байх вэ гэдэг эдийн засгийн тооцооллуудыг бид нар тооцож үзсэн. Тэгээд эдийн засгийн тооцоолол нь бол хэрэв энэ хуулийг хэрэгжүүлэх юм бол жил бүхэн нийгмийн даатгалын сан дээр нэг 38-аас 45 тэрбум төгрөгийн нэмэлт зардал гарах нэг ийм асуудал үүсээд байгаа юм. Тэгээд өнгөрсөн хугацаанд бид нар ер нь энэ даатгалын бус зориулалтаар нийгмийн даатгалын сан дээр хэрэгжүүлсэн улс төрийн шинж чанартай энэ хуулиудыг хэрэгжүүлэхэд бол 6.8 их наядын ачааллыг энэ сан дээр үүрүүлсэн байна аа. Энэ яг юу гэсэн үг вэ гэхээр шударгаар НДШ-ээ төлөөд явж байгаа ирээдүйдээ тэтгэвэртээ хуримтлал хийгээд явж байгаа иргэдийн хуримтлалаас шударга бусаар гэдэг юм уу хэсэг цөөнх хэсэгт нийгмийн хэсэгт ингээд ийм даатгалын бус хөнгөлөлт үзүүлж байгаа ийм улс төрийн шийдвэр. Тэгэхээр энэ бол ийм байж болохгүй зохимжгүй.

Өнгөрсөн хугацаанд бол яг малчид руу чиглэсэн бид нар 4 хууль баталсан юм байна лээ. Ажилласан жилийг 10 жилийг нөхөн тооцсон, тэтгэврийн малчдын тэтгэврийн насыг 5 насаар наашлуулсан. Ингээд нийгмийн даатгалын нөхөн тооцох тухай шимтгэл нөхөн тооцох тухай хуулийг 7 жилийн хугацаанд сунгасан. Энд бид нар нийт 380 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. 380 тэрбум төгрөг. Энэ бол бид нарын мөнгө биш, төсвийн мөнгө биш. Энэ бол шударгаар НДШ-ээ төлөөд явж байгаа хүмүүсийн тэр даатгалаас л хумсалж байгаа хэлбэр юм байгаа юм.

Тэгэхээр энийг 2026 оны Байнгын хорооны дарга ч гэсэн нэлээн энэ хуулийн санаачлагчийн нэг нэлээн хууль хэрэгжүүлэхийг шахаж шаардаж ажиллаж байгаа. Тэгээд бид нар 2026 оны төсөв улсын төсөв батлагдахад та бүгдэд энэ хуулийг хэрэгжүүлэх энэ эх үүсвэрийг баталж өгөөч л гэж хүсэж байгаа юм.

Тэгэхгүй бол эх үүсвэргүй. Бид нар ер нь бусдын НДШ-ээс нэг хэсэг улсууд одоо эд нар ингээд хариуцлагагүй байсан юм байна. Ингээд тэтгэвэрт гарахад дөхчихжээ. Нийгмийн даатгалыг нь ингээд нөхөн тооцъё гэдэг ийм хуулийг ерөөсөө хэрэгжүүлж болохгүй гэж би ойлгож байгаа салбарын сайдын хувьд. Одоо бол малчид дээр бид нар малчдын тухай Нийгмийн даатгалын шинэ хууль хэрэгжиж эхлээд төрөөс 50 хувийг нь дааж байгаа шүү дээ НДШ-ийг нь эхнийх нь 5 жил.

Тэгэхээр ийм хөнгөлөлт авчихсан ямар ч хүн байхгүй шүү дээ Монгол Улсад. Тэгэхээр ингээд нэг хэсэг нийгмийнхээ давхаргыг ингэж илүү хөнгөлөлт, үзүүлдэг, хөнгөлөлт үзүүлэхдээ бусдын төлсөн НДШ-ээс бусад улсуудад ингээд ийм хөнгөлөлт үзүүлдэг ийм тогтолцоо байж болохгүй л гэж харж байгаа юм. Тэгээд одоо тэтгэврийн шинэчлэлийн хууль, НДШ-ийн хуулийг Улсын Их Хурал дээр удахгүй өргөн барина. Энэ хүрээнд ингээд цөмөөрөө их сайн ярилцах ёстой юм байна гэж харж байгаа.

Өнөөдөр Монгол Улсад тэтгэвэрт тогтоолгож байгаа 2 хүний нэг нь хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэрт гарч байгаа шүү дээ. 2 хүний нэг нь. Хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэрт гарч байгаа ажил мэргэжлийн жагсаалт өнөөдөр 1415 болсон байна. Монгол Улсад 4 мянга гаруй мэргэжил бүртгэл бүртгэлтэй байдаг. 4 хүний нэг нь ингээд хөнгөлөлттэй нөхцөлөөр бусдынхаа төлсөн НДШ-ээр илүү тэтгэвэр авдаг ийм шударга бус тогтолцоог л цөмөөрөө халах ёстой юм байна аа. Энэ дээр тэтгэврийн шинэчлэлүүд явагдана л гэж ингэж харж байгаа.

Г.Тэмүүлэн: Энх-Амгалан сайд тайлбар өгсөн. Нэмж Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Тэгвэл энэ хуулийн заалт энэ жил лав хэрэгжихгүй юм байна. Ирэх жил хэрвээ төсөв тавигдвал хэрэгжиж болох юм гэсэн тийм ойлгоц авлаа. Өөр заалтууд байгаа шүү дээ? Орон сууцын ипотекийн зээлд хамруулах, нөгөө хүүхдийн сургалтын төлбөр хөнгөлөлттэй зээл энэ тэр гээд нийгмийн асуудлыг нь шийдсэн олон заалтууд байгаа. Тэгээд эдгээрээс ямар нь хэрэгжээд ямар нь хэрэгжих боломжгүй байгаад байгаа юм.

Г.Тэмүүлэн: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Наранбаяр сайд энд бас байна. Тэгээд Наранбаяр сайд яах ёстой байх энэ хуулийн заалт хэрэгжинэ тиймээ. Тэгээд энэ сая журмаа Засгийн газраар би батлуулсан гэж ойлгосон. Одоо малчны нэг хүүхдийг нөгөө мэргэжлээр нь ХАА-н мэргэжлээр тиймээ, хөдөө аж ахуйн мэргэжлээр сурахад Боловсролын зээлийн сангаас зээл олгох энэ заалт хэрэгжинэ. Ипотекийн зээл олгох заалт хэрэгжинэ. Ипотекийн зээл олгох заалт яагаад удаашралтай байсан юм бэ гэхээр энэ малчны нөгөө хөдөөд амины орон сууц барихад тэрийг нь ипотекийн зээлээр санхүүжүүлэх энэ амины орон сууцын стандарт батлагдаагүй байсан юм гишүүн ээ.

Тэгэхээр энэ стандартаа сая Барилгын яаман дээр батлагдсан.

Тийм учраас ипотекийн зээл гэхээр нэг хязгааргүй зээл байдаг юм шиг бид нар ойлгож болохгүй. Жилд бид нар 1.2 их наядын л зорилттой бүлэгт байгаа энэ зээлийг олгоё гэж байгаа. Тэгэхээр энэ хүрээнд бол 50 хувийг нь хөдөө орон нутаг буюу сум хөдөөд амьдарч байгаа малчид төрийн албан хаагч нарт зориулсан ийм зээлийн бодлогууд явна аа. Бусдыг нь бол Наранбаяр сайд хариулах байх.

Г.Тэмүүлэн: Наранбаяр сайд нэмж хариулъя.

Н.Наранбаяр: Баярлалаа. Би маш товчхон хариулъя.

Энэ бол боловсролын зээлийн сангийн журмыг сая Засгийн газраар оруулж шинэчилж батлуулсан. Энд бол Малчны тухай хуулийн 4.2.5 дээр байгаа энэ заалтыг хэрэгжүүлэх энэ заалт нь ороод ирсэн. Тэгэхээр тэр 2025 оны 1 сарын 1-ээс хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлсэн энэ хуулийг одоо бид энэ 9 дүгээр сарын 2025-2026 оны хичээлийн жилд энэ оюутнуудыг хүлээж авах, энэнтэй нь холбоотойгоор хэрэгжүүлж эхлэх гэж байна аа.

4.2.5 дээр нь юу гээд заасан бэ гэхээрээ зэрэг малчнаар 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан малчны нэг хүүхдийг МАА, тэжээл, бэлчээр судлалын

чиглэлийн мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй суралцуулах гэсэн. Ийм байгаа. Тэгэхээрээ бид энэ журамдаа өөрчлөлт оруулаад малчны нэг хүүхдийг сургах ийм боломжийг хангачихсан байгаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Наранбаатар гишүүн нэмж асууя.

Н.Наранбаатар: Тэгээд эрүүл мэндийн үзлэгт жилд нэг удаа хамруулна гэсэн байгаа. Тэр заалтын хэрэгжилт ямар байгаа бол? Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Тэмүүлэн дарга маань энэ хуулийг санаачлагчийн нэг учраас энэ хуулийг мөрдүүл гэдэг шаардлагыг надад өдөр бүхэн сануулж байгаа. Тийм учраас энэ хуулийг би сүүлийн үед маш их сайн уншлаа. Тэгээд малчдад маш их том боломжууд гаргасан юм байна. Тэгэхээр зээл бол хоршооны зээл явж байгаа Наранбаатар гишүүн ээ.

Сая Наранбаяр сайдын хэлсэн малчны нэг хүүхдийг тэр тухайн ХАА-н мэргэжлээр сурах тэр юунууд нь эрхүүд нь нээгдэж байгаа. Малчныг буюу гэр бүлийн малчин гэр бүлийг жилд нэг удаа нөгөө эрүүл мэндийн урьдчилсан үзлэг оношилгоонд хамруулах энэ хуулийн заалт байгаа. Энэ бас хэрэгжээд явж байгаа гэж ойлгосон. Мөнхсайхан гишүүний юугаар бол. Одоо ингээд хэрэгжээгүй ганцхан заалт байгаа. Энэ бол нөгөө малчдын нөхөн даатгалын хууль байгаа. Энийгээ цөмөөрөө тэтгэврийн шинэчлэл, НДШ-ийн энэ хэлэлцүүлэг Улсын Их Хурал дээр явах үед бол тодорхой нэг дундын шийдэл олъё гэсэн ийм ойлголттой байна.

Г.Тэмүүлэн: Өөр асуулттай гишүүд байхгүй байна.

2 зүйлийг нэмж нэг тодруулаадахъя. Энх-Амгалан сайд гишүүд сая хэлж байна. Болормаа гишүүн хэлж байна. Австрийн ерөнхийлөгч энэ 2025-2028-ны хооронд ирэх нэг дэх өдрөөс 3 дахь өдрийн хооронд бол Монгол Улсад айлчилж байгаа. Тэгээд Засгийн газар сая 5 сарын 19-нд энэ 2 улсын нийгэм хамгааллын тухай 2 улсын хооронд энэ хэлэлцээр ингэж орж ирж байна. Тэгээд манай Байнгын хороо бол өнөөдөр уг нь хуралдах товгүй байсан. Яаралтай горимоор ингээд орж ирж байгаа.

Тэгээд уг нь манай Австрид бол дэлхийд л энэ цаг баримталдаг албаны зохион байгуулалт сайтайгаараа л гайхагддаг улс орон. Тэгээд уг нь бол энэ дэг журам баримталдаг энэ ард түмнийг та нар дагуулж чирээд байна уу, үгүй юу? Уг нь 1 сарын өмнө л бараг энэ айлчлал товлөгдсөн байна гэж баймааргүй юм. Өндөр дээд түвшний албан айлчлал бараг жилийн өмнө л товлөгдсөн байх.

Тэгэхээр дараа дараагийн асуудлууд дээр хариуцлагатай хандаарай. Цаг хугацаанд нь тулгаж оруулж ирдэг энэ асуудлууд байж болохгүй шүү.

Хоёр, яах вэ энэ зарчмын хувьд зөв. Бүрэн дүүрэн дэмжиж байна. Байнгын хорооны гишүүд бүгдээрээ л хэлж байна. Бид нар гадаадад байгаа Монголчуудынхаа нийгмийн хамгааллын асуудлыг хөндөж дэмжих ёстой тодорхой энэ хэлэлцээр хоорондын асуудлыг бол шийдэх ёстой гэдэг байр суурьтай байгаа.

Би зүгээр нэг тоог л асуух гэсэн юм. Одоо яг үндсэндээ бид нарын санаа зовоод байгаа асуудал энэ хүн амын бодлоготой холбоотойгоор, хөдөлмөр

эрхлэлтийн түвшинтэй холбоотойгоор, Монгол Улсын нөгөө талтай энэ эдийн засгийн баталгаатай холбоотойгоор энэ ажилгүйдлийн түвшин маань хэд байна? Өнгөрсөн онтой харьцуулахад хэдэн хувиас хэдэн хувь болж ажилгүйдлийн түвшин нэмэгдээд байна? Хөдөлмөр эрхлэлтийн түвшин одоо ажиллах хүчний оролцооны түвшин бас өнгөрсөн онтой харьцуулахад хэдэн хувиас хэдэн хувь руу орж буугаад байна? Үндсэндээ яг гадаадад та бүхэн маань сүүлийн байдлаар авсан манай яг хөдөлмөрийн насны Монгол иргэд маань хэдэн зуун мянган хүн байна. Би буруу мэдээлэл аваагүй бол багцаагаар нэг 220 мянган Монгол иргэд буюу тэнд бол албан ёсны бүртгэлтэйгээр байна гэж байгаа юм. Тэгээд энэ дээр нэмэгдэх нь магадгүй хараар нэмэгдэж магадгүй л дээ.

Тэгэхээр энд бол үндсэндээ би зүгээр багцаа тоо статистик аваад үзэхээр нийт яг энэ хөдөлмөрийн насны энэ байгаа иргэд маань бол үндсэндээ тэнд нэг гадаадад дунджаар 7.2 жил ажиллаж амьдарч сурч боловсорч байна гэсэн мэдээлэл гарч ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр 7.2 жил гэдэг бол үндсэндээ их урт хугацаа байна. Тэгээд дандаа дээд боловсролтой дандаа ид хөдөлмөрийн насны 25-аас 40 орчим насны залуучууд байна гэдэг тоон судалгаа гарч ирж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр яг ямар мэдээлэл байна аа? Одоо бид нар энэ гадаадад байгаа та бүхний оруулж ирж байгаа хэлэлцээр үндсэндээ гадаадад ажиллаж амьдарч байгаа Монгол Улсынхаа иргэдийн нийгмийн баталгааг тэнд нь хангах гэдэг юм уу энд хангах гэдэг юм уу энэ асуудал яригдаж байна л даа. Тэгэхээр бид нарын хувьд үндсэн гол толгойны өвчин болчихоод байгаа асуудал маань буцаан авчрах бодлого маань өөрөө төрийн бодлого яах юм бэ?

Ямар энэ эдийн засгийн зөвшөөрөл байх юм бэ? Нийгмийн баталгааг нь яах юм бэ? Ямар төрийн зөв бодлого байх юм бэ гэдэг асуудал яриад байгаа юм. Өнөөдөр бид нар ажилгүйдлийн түвшин магадгүй өнгөрсөн оныхтой харьцуулаад аваад үзэхээр 5.4 хувь болоод нэмэгдлээ гэдэг асуудал гарч ирээд байгаа байхгүй юу 5.4 хувь. Гэтэл би 5.4 дээр нэмэх нь магадгүй энэ 220 мянга байна уу хэдэн мянган хүн байна гадаадад байгаа иргэдээ нэмж тооцох ёстой гэж бодоод байгаа юм. Эрс шинэчлэлийн бодлого бид нар энэчээ буцааж авчрах ажлын байр бий болгох эрс шинэчлэлийн бодлого байхгүй бол болохгүй болчихоод байгаа байх.

Тэгэхээр бид нар үндсэндээ эрс шинэчлэлийн бодлого гэдэг бол үндсэндээ энэ тэр буцааж авчрах цалин хөлсийг нь нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болох ажлыг мэдээж хувийн хэвшил хийнэ. Төр хийж чадахгүй шүү. Тэгэхээр энэ дээр та хэд маань ер нь яг ямар буцааж авчрах энэ бодлого хөшүүргийг хийх гээд байгаа юм бэ? Жишээ нь хамгийн сайн хэрэгжсэн улс орон гээд аваад үзэхээр Солонгос улс, Израил улс ч гэдэг юм уу татах, суурьших нөхцөлийг нь бий болгох гээд бодлого хөтөлбөр гаргаад явж байсан, үр дүнд хүрсэн.

Манайх бол Баяр даргын үед зөгийн үүр гээд нэг хөтөлбөр хэрэгжүүлсэн. Ингээд тэр бол уриа лоозон төдий болоод ингээд өнгөрчихсөн.

Тэгэхээр энэ дээр та хэд маань яаж энэ 200-аас хол давсан мянган иргэдээ Монгол Улс руу татаж авчрах юм бэ. Энэ их том толгойны өвчин асуудал болж байна шүү. Үндсэндээ Монголчуудаа авчирч чадахгүй, ингээд гаднаас бараг хямд ажиллах хүчээ авах асуудал үндсэндээ бид нар ярьдаг ийм хэмжээнд л очоод байна. Энэн дээр нэг та нэг бодлогын байр суурь төлөвлөгөөгөө хэлээч л гэх гэсэн юм. Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: 3 минутаар өгчих үү? Байнгын хороон дарга. Том асуудал хөндөж ярьж байгаа учраас. Энэ Эм Эм Си Жи гээд нэг ийм судалгааны компаниар манайхан 2 жилийн өмнө Булгантуяа сайд байхдаа их том энэ ажиллах хүчний асуудал, хөдөлмөрийн зах зээлийн асуудалдаа нэлээн том судалгаа хийсэн юм билээ. Би энийг Байнгын хорооныхоо гишүүдэд хүргүүлж гэж бодож байна. Энэ их тийм зөв судалгаа болсон. Бодлогын зөвлөмжүүд нь их сайн зөвлөмжүүд өгсөн. Тэгээд хамгийн гол зүйлд яагаад энэ Монголчууд гадагшаа дайжаад байгаа юм, яагаад эх орондоо ажиллах амьдрах хүсэлгүй байгаа юм, ерөөсөө л тэгээд л хөдөлмөрийн үнэлэмжийн асуудал шүү дээ.

Өнөөдөр нэг цагт Монгол хүний хөдөлмөрлөж байгаа нэг цагийн хөлсөнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр доллар 10 цент байна гэдэг бол тэгээд л их л бага байгаагийн л шинж.

Тийм учраас хамгийн багадаа нэг 10-аас 15 доллар болж байна шүү дээ. Тэгэхдээ ийм салбар байгаа шүү дээ манайд. Нэг цагийн хөлс нь 10-аас 15 доллар үлдсэн салбар байна. Уул уурхайн салбар байна. Банк санхүүгийн салбар байна. Мэдээлэл технологийн салбар байна. Тэгэхээр бусад салбарууд, Энхбаяр сайд байх шиг байна. Хамгийн бүтээмж муутай салбар буюу цалин хөлсний муутай байгаа үнэлэмж муутай байгаа салбарууд ХАА-н салбар байгаа.

Тийм учраас бол энэ хөдөлмөрийн зах зээлийн бодлого бол ганцхан Хөдөлмөрийн яамны асуудал биш. Салбар дундын зохицуулалтын асуудал. Тэгээд энэ Засгийн газар хэрэгжүүлж байгаа хүргэхээр зориод байгаа нэг хүнд ноогдох ДНБ-ийг 10 мянган долларт хүргэхивэл Монгол хүний авах цалин мянган доллар л болдог юм байна лээ шүү дээ. Мянган доллар. Манай багш нарын хүсээд байгаа, эмч нарын хүсээд байгаа цалин бол мянган доллартой л больё гээд байгаа шүү дээ тийм Наранбаяр сайд аа.

Тийм учраас нэг хүнд ногдож байгаа ноогдож байгаа ДНБ 10 мянган доллар болохын төлөө л бид нар хичээж ажиллах ёстой юм байна. Ер нь бусад улс орнуудад ч гэсэн хийсэн судалгаа энэ түүх Турк, Польш, Украин зэрэг ингээд нэг ажиллах хүчин экспортолдог, Филиппин гээд улсуудын хийсэн судалгаагаар бол ер нь Турк иргэд маань Герман руу Европ руу цагаачлахаа больсон гэхээр ДНБ нь 12 мянган доллар хүрчихсэн юм байна лээ. Польш улс ингэсэн юм байна лээ. Тэгээд энийгээ ингээд нэг ийм 10 мянган долларт хүрч байгаа тохиолдолд бол залуучууд тухайн эх орондоо ажиллах ийм боломжууд нь байдаг юм байна лээ. Энэ бол нөгөө брэйн гэж ярьдаг. Нөгөө тархины гоожилт гэж ярьдаг. Тэгээд яаж бид нар брэйн гень болох вэ гэдэг асуудлыг бид нар энэ Монгол төрийн ийм бодлого байх ёстой гэж ойлгож байгаа. 3.5 сая иргэдтэй. Өнөөдөр 1.2 сая иргэн ажил хөдөлмөр эрхэлдэг, 900, 800 мянган хүн нь ажил хөдөлмөрөөр ийм настай мөртөө ажил хөдөлмөр эрхэлдэггүй нэг ийм сонин тогтоцтой болчихсон учраас энэ бид нар тогтолцоо нь хөдөлмөрийн зохицол дээр тогтолцооны шинэчлэл их зайлшгүй шаардлагатай байгаа.

Ажилгүйдлийн түвшин 5.3 гэсэн тоо байгаа. Статистикийн 1 дүгээр улирлын юугаар гүйцэтгэлээр. Энэ бол өнгөрсөн жилээс буугаагүй үзүүлэлт. Ажиллах хүчний оролцоо өнгөрсөн жилээс 6 хувиар нэмэгдсэн юм байна лээ. Ажиллах хүчний оролцоо 53 байж байгаад 61 болж байгаа гэдэг нь бол ажиллах хүчний оролцоо нэмэгдсэн гэсэн нэг ийм тооцоолол статистикаас зарлаж байгаа ийм тооцоолол

байна. Энэ бол одоо ингээд эдийн засаг идэвхжиж байгаа томоохон мега төслүүд хэрэгжиж эхлэх ийм боломжууд бүрдэж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд энэ би метроны төслөөр би жишээ аваад ярья. Сая Нямбаатар дарга метро Улаанбаатар хотод барих энэ төслийг эхлүүлэхэд ер нь метроны чиглэлээр суралцсан Монголчууд, метроны чиглэлээр ажиллаж байгаа Монголчуудынхаа тооцоо судалгааг хийж үзсэн юм байна лээ. Энэ дээр бол яг метроны инженерээр ажиллаж байгаа метронд ажиллаж байгаа бүтээн байгуулалт оролцсон нэг 600 орчим залуучуудын тооцоо гарсан юм байна лээ.

Тэгээд энэ залуучуудыг урьж байгаа. Ингээд метро байгуулах, цаашдаа метро ажиллуулах чиглэл рүү. Тэгэхээр энэ цаашаа нөгөө 13 мега төслүүд хэрэгжих энэ боломжуудыг гарч ирэх юм бол цаашдаа Монгол Улсад бол ингээд яг энэ УЦС, сэргээгдэх эрчим хүч ч гэдэг юм уу Монгол Улсад шинээр бий болж байгаа эдийн засгийн салбарууд дээр бол хүрч ирж ажиллах энэ залуучуудын хүсэл тэмүүлэл их байгаа юм байна, их өдөөгдөж байгаа юм байна гэсэн нэг ийм ойрын жишээ хэлье.

Г.Тэмүүлэн: Нэг ийм л асуудал байгаа. Яах вэ мэдээж би онцолж хэлээд байгаа зүйл нь тэр цалин хөлс, эдийн засгийн баталгааны асуудал гэхээр үндсэндээ бид нар эдийн засгийн бодлого дээрээ цалин хөлс болоод хөдөлмөрийн бүтээмжийн асуудал дээр нэг эрс шинэчлэлийн асуудал хийхгүй бол буцааж татах ч гэдэг юм уу нийгмийн баталгааг хангах бодлогуудыг гаргахгүй бол болохгүй болчихоод байна л гэдэг асуудлыг хөндөж яриад байгаа шүү дээ. Тэгээд үндсэндээ би хувийн хэвшил хийнэ гэдэг асуудлыг яриад байгаа юм. Тэрнээс юу гэдэг юм төрөөс хүчээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг татаад гэдэг юм уу, эсвэл юу гэдэг юм хувийн хэвшилд ажиллах, өргөжих тэлэх боломж бололцоог бүрдүүлэхгүйгээр бол энэ бий болно гэж байхгүй. Тэгээд буцаж ирнэ ч гэсэн асуудал байхгүй.

Тэгэхээр энэн дээр л уг нь нэг сайн анхаарч ажиллаад та хэд нэг хувийн хэвшлийнхнийгээ дэмжсэн татвар болоод нийгмийн даатгалтай холбоотой эд нар өсөж тэлэх томрох орон зайг нь бий болгож өгмөөр байгаад байгаа юм. Тэрнээс өнөөгийн яг тогтолцоогоор бол ямар нэг байдлаар хүн ажил хөдөлмөр хийх болоод аж ахуйн нэгж байгууллагууд, компани, хувийн хэвшил томрох боломж болчихсон үндсэндээ байхгүй болчихоод байна шүү дээ. Энийг тэгэхээр бол нэг том зургаар хармаар байна л гэдэг асуудал байгаа юм.

Саяын ажилгүйдлийн түвшин бол 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 5.3 хувьтай байсан юм. Тэгээд 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар буюу 3 сарын 31-ний байдлаар 5.4 хувь болж 0.1 функтээр өсөөд байгаа. Ажиллах хүчний оролцооны түвшин 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 62.2 хувьтай байсан. Одоо хөдөлмөр эрхлэлтийн түвшин 58.9 хувьтай болж ингээд унаад байгаа байхгүй юу. Тэгэхээр үндсэндээ хөдөлмөр эрхлэлтийн түвшин унаад байна. Өнгөрсөн онтой харьцуулахад. Ажилгүйдлийн түвшин бол бас ингээд нэмэгдээд байгаа энэ асуудлууд байна аа.

Тэгэхээр бол энэ нэг талдаа үндсэндээ анхаарах л асуудал. Хэдий бага хувиар ч гэсэн энэ тренд цаашаагаа явбал буруу байна гэдгийн дохио бол гарч ирж байна гэж хараад байгаа юм.

Би нэг санал нийлэхгүй байгаа зүйл бид нар анхаарах ёстой зүйл. Ийм зүйл байгаад байна аа. Энэ дээр яг салбарын мэргэжлийн яам ямар бодолтой байгаа юм бэ? ДНБ гэдэг зүйлийг л их жишээ болгож яриад байх юм. ДНБ тэллээ томорлоо

гээд байдаг. ДНБ тэлэхийн хэрээр Монгол хүний амьдралын чанар амьжиргаа орлого нь дээшлэхгүй байгаа байхгүй юу. Наалдац байхгүй болчихоод байгаа. Хүртээмжтэй өсөлтийг бид нар бий болгож чадахгүй болчихоод байгаа юм аа.

Тэгэхээр энүүгээр хэмжиж яригдах чинь өөрөө буруу болчихоод байна аа. Бид нар бол GDP гэхээсээ илүү бараг GNP гэдэг юм уу эсвэл нэг хүнд ноогдох орлогын асуудлыг, хувь хүний хөгжлийн асуудлыг яах ёстой болчихоод байгаа юм. Энэн дээр жоохон та хэд тооцоо судалгаа наад бодлого дээрээ тооцоогоо хийхдээ бас арай өөрөөр л төсөөлж харж, ярьж хөөрмөөр байна л гэсэн нэг асуудлыг хөндөх гэсэн юм. Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Тэмүүлэн дарга аа ийм юм байна лээ. Энэ манай нөгөө хөдөлмөрийн зах зээлийн статистик чинь улирлын шинж чанарт нөлөөлөл их байдаг. Одоо жишээ нь та нөгөө өнгөрсөн оны гүйцэтгэл 1 дүгээр улирлын гүйцэтгэл л яриад байна л даа. Тэгэхээр одоо ингээд энэ хавар зуны улиралд манайх их идэвхэждэг. Тэгэхээр энэ нөгөө нэг яг л ч ажиллах хүчний оролцоо энэ ажилгүйдлийн түвшин чинь намар бол их өөр тоо гарна. Намар 3 дугаар улирлын гүйцэтгэлээр.

Тэгэхээр яг энэ нэг манай энэ хөдөлмөрийн зах зээлийн бас нэг ийм онцлог байна уу гэсэн нэг ийм юу хараад байгаа юм. Би зүгээр энэ статистикуудын ингээд нэг ийм хөдөлж байгаа хөдөлгөөнүүдийг харахаар яг аль улиралд нь, аль түвшинд нь унаад аль түвшинд нь өсөөд байна гэдэг энэ улирлын шинж чанартай байна уу гэсэн нэг ийм юу байгаа. Тантай санал нэг байна аа. Ганцхан ДНБ-ээр ингээд үзээд хэмжээд явдаг бол энэ жаахан өрөөсгөл байгаа. GNP үндэсний нийт бүтээгдэхүүний орлого.

Г.Тэмүүлэн: Нэмээд Энх-Амгалан сайд хариулья.

Л.Энх-Амгалан: Гадаадад ажиллаж байгаа Монголчуудынхаа юуг ч гэсэн бид нар тооцох л ёстой юм байна лээ шүү дээ. Тэгээд бид нарын тооцогддоггүй GDP-тооцогддоггүй энэ салбарууд байна. Нас барахуйн эдийн засаг энэ тэр гэх мэтчилэнгээр энийгээ бид нар эдийн засгийн тооцооллуудаа зөв хийж явах нь тантай санал нэг байна аа. Тэгээд яах вэ мэдээж энэ эдийн засгийн өсөлт нөгөө Монгол хүнд яаж наалдаж байна гэдэг асуудал байгаа. Энэ дээр одоо энэ Засгийн газраас хэрэгжүүлж байгаа 13 мега төслийн цаана бол 4 том бодлого явж байгаа. Энэний нэг бодлого нь бол энэ хүний хөгжлийн бодлого, тэр тусмаа хүний хөгжлийн индексийн асуудал. Хүний хөгжлийн индексийг бид нар одоогийн байгаагаас 10 байраар урагшаа ахиулья гэдэг бол яг энэ эдийн засгийн өсөлтийг яг хүн амын орлого, өрхийн орлого, Монгол хүний өрхийн орлого, бүтээмж, цалин, тэгээд мэдээж энэ боловсролын чанар хүртээмж эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг л хүргэж байж л энэ эдийн засгийн өсөлтүүдийг иргэддээ наалдуулах ийм л бодлого явах болов уу гэж харж байгаа юм.

Тэгээд тантай санал нэг байна. Энэ бүтээмжийг Монгол хүний бүтээмжийг өсгөх чиглэл рүү бид нар энэ Монголын төр ер нь анхаарах ёстой. Бид нар энэ салбаруудын бүтээмжүүдийг өсгөх чиглэлээр энэ салбарын удирдлагууд, салбарын сайд нартай бас ийм нэгдсэн юунууд хийж байгаа, хэлэлцүүлгүүд хийж байгаа. Тэгээд бид нар энэ Японы Азийн бүтээмжийн төвтэй хамтарч энэ Монголын бүтээмжийг өсгөх энэ мастер төлөвлөгөөг хийж байгаа гэдгийг энэ далиманд мэдээлэл болгож хэлье гэж бодож байна.

Би нэг зүгээр яах вэ санал хэлчихье дээ. Тэгээд санал хураалт явуулъя.

Наранбаатар гишүүн түрүүн хөндсөн асуудал дээр би нэг тайлбар хэлэх нь зөв байх аа. Би зүгээр одоо тэр гол ажилтай холбоотой, МАА-н салбартай холбоотой асуудал дээр бол би хөндөөд байгаа асуудал ерөөсөө л зарчмын асуудал. Энэ хууль дээдлэх зарчмыг л асуугаад байгаа юм.

Тэгээд үндсэндээ Монгол Улс бол Улсын Их Хурал нь өөрөө төрийн эрх барих дээд байгууллага. Улсын Их Хурлаасаа гүйцэтгэх засаглал нь томилогддог. Засгийн газраа бид нар байгуулдаг. Улсын Их Хурлын ямар ч хуулийг хэн нэгэн шүүх эрх бол байхгүй. Тэрийг гүйцэтгэх засаглал хэрэгжүүлэх үүрэгтэй. Үндсэндээ бид нар энэ төрд итгэх итгэл чинь өөрөө Улсын Их Хурлаасаа хуулиасаа, хууль дээдлэх зарчмаасаа л бол хамаарч байгаа. Хуулийн дор бүгд эрх тэгш эрхтэй байх ёстой. Тэгэхээр энийг бас ингэж нэг талдаа нэг хүний явцуу эрх ашгаар бол явцууруулж болохгүй шүү.

Хуулийг Монголын төрийн доор бүгд дээдлэх ёстой. Засгийн газар заавал хэрэгжүүлэх үүрэгтэй. Энийг хэн нэгэн шүүдэг эрх байхгүй. Төсөв санхүүгийн асуудал ярьж байгаа бол төлөвлөлт сайтай байх хэрэгтэй байна. Энэ хууль 2024 оны 7 сард хэрэгжиж эхэлсэн. Төсөв өөрөө 9 сард өргөн баригдсан. Төсвийн ажлын хэсгийн үеэр ч гэсэн бид нар асууж байсан. Ямар нэг хэрэгтэй шаардлагатай зүйл бид нар нэгд хүний хөгжлийн л асуудал. Эрүүл мэнд, боловсрол, нийгэм, хамгаалалтын асуудлууд юу байна. Ажлын хэсэг дээрээс бид нар шийдье гэж 3 юм асуухад манай Боловсролын яамныхан болоод ЭМЯ-ныхан бүгд саналаа өгөөд шийдүүлсэн асуудал. Хавдрын эмнэлгийн асуудал байна. Сургууль цэцэрлэгийн хүртээмжийн асуудлуудыг бид нар тэнд шийдэж байсан.

Тэгэхээр ийм зүйлүүд дээр бол жоохон ажил хэрэгч хандмаар байна аа. Уг нь бол та хэд зохион байгуулалт сайтай л байх ёстой. Уг нь энэ жил өшөө төсвийн орлого тасарч байгаа жил дээр бараг 50-аас 60 орчим тэрбум төгрөг ч нэмэгдэх ийм тооцооллыг бид нар хийж байсан. Энэ хууль өөрөө үндсэндээ 2 жил гаруй хугацаанд ХААЯ-ны, ХААИС-ийн бүх эрдэмтэд судлаачид боловсруулаад гаргасан бодлого шүү. Судалгаан дээр шинжлэх ухаанчаар хандсан бодлого байгаа шүү. Үндсэндээ энэ өнгөрсөн оны өвлийн зуд турхнаас болоод 30-аас 40 мянга орчим малчид Улаанбаатар хот руу нүүж ирсэн байна.

Энэ хэмжээгээр ажилгүйдлийн түвшин нэмэгдэж байна. Бид бүхэн дээр ачаалал өөрөө нэмэгдэж байна. Гадагшаа гарч байгаа хүмсийн тоо нэмэгдэж байна. МАА-н салбарыг тогтвор суурьшилтай ажиллах боломж бололцоо байхгүй болж байна. Энэ бол нэг талдаа Монгол төрийн бодлогын алдаа. МАН 2016 онд энэ бодлогыг гаргаж ирсэн. Энэ бодлогыг бүрэн хэрэгжүүлээгүй. 3-аас 4 удаа дандаа хойшлуулдаг байсан. Ковидын үеэр арга заль зохиогоод хатуу хөл хориотой 6 сар хэрэгжүүлсэн болоод нэг ч хүн хамрагдаагүй шахуу ингээд шахуу дууссан юм аа.

Тэгэхээр Монголын төр амласан амлалт биелүүлдэг хэрэгжүүлдэг байх шаардлагатай л гэж үзэж ингэж хийсэн. Үндсэндээ одоо юу гэдэг юм Монгол Улсын эдийн засгийн баталгаа энэ МАА-н салбар шүү дээ. ХАА-н салбар.

Тусгаар тогтнолын баталгаа чинь бас энэ хүн байгаа. Хүний хөгжил дээр бид нар анхаарах ёстой. Нэгдэл сангийн аж ахуй тараад бутарсан, архив бүртгэл, данс

нь байхгүй болчихсон. А данс байхгүй болчихсон. Тэр хүн ажилласан хөдөлмөр жилээ бүтнээр нь үнэнээр нь би бүртгүүлье гэхээр юу гэдэг юм Монголын төр нь данс бүртгэлийг нь байхгүй болгочихсон хүмүүсийг бид нар хаяж болохгүй шүү дээ. Тэгэхээр энийг л бид нар хүний эрх ашигт хөндөх талаас нь бол хамгаалж үзье л гэсэн хүнээ харсан бодлого байсан шүү л гэдгийг хэлье.

Тэгээд дараа дараадаа Засгийн газар дээр нь анхаарч үзнэ биз дээ. Баярлалаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Энх-Амгалан сайд үг хэлье.

Л.Энх-Амгалан: Баярлалаа. Өнөөдөр манай Байнгын хорооны гишүүд маань бас ингэж Байнгын хорооны ээлжит бус хурлыг хийж энэ өндөр ирцтэйгээр энэ Австрид амьдарч байгаа гадаадад амьдарч байгаа Монгол иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах ийм хуулиудыг улс төрийн манлайлал үзүүлж ингэж соёрхон баталж өгч байгаад талархал илэрхийлье ээ. Гадаадад амьдарч байгаа 213 мянган иргэдийнхээ өмнөөс, нэгд нь.

Хоёрт нь бол Тэмүүлэн гишүүн ээ би зүгээр энэ тоог хэлчихье гэж бодож байна. Яагаад гэвэл Наранбаатар гишүүн ч гэсэн асуусан учраас энэ ийм юм байна цөмөөрөө. Одоо яг энэ 2012-2017 онуудад ажилласан жил, НДШ-ийг нөхөн тооцсон тухай хуулийг хэрэгжүүлэхэд нийт Монгол Улсын хэмжээнд 607 мянган хүний нөхөн даатгал хийгдсэн. Эндээс 40 мянган малчин хамрагдсан юм байна лээ 10 жилээ нөхөж авсан гэсэн үг. Ингээд энэ малчдын маань нөгөө тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр төлж авсан энэ жил дээр цуглуулсан мөнгө нь 2 тэрбум төгрөг. Өнөөдөр тэтгэвэрт гараад өнгөрсөн хугацаанд энэ 40 мянган малчнаа 2 тэрбум төгрөгийн шимтгэл нөхөн тооцоод тэр үеийнхээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр төлөөд, тэтгэврийн сангаас бусдын төлсөн НДШ-ийн сангаас 120 тэрбум төгрөг авч. 120 тэрбум төгрөг. Хоёрхон тэрбум төгрөг хуримтлуулаад бусдын төлсөн шимтгэлээс 120 тэрбум төгрөг авч байна аа. Энэ шударга ёс уу? Энэ ариун явдал уу гэдгийг бас бид нар нэг үнэлэлт дүгнэлт хийх ёстой юм.

Ингээд 2020-2022 онд Малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцох тухай хууль хэрэгжээд ингээд үндсэндээ 31800 малчин 76 тэрбум төгрөг НДШ-д төвлөрүүлээд буцаад 314 тэрбум төгрөг авч байгаа юм. Буцаад 314 бусдын шимтгэлээс авч байгаа байхгүй юу. Ингээд нөгөө малчдын тэтгэврийн насыг наашлуулсан хууль 2024 онд хэрэгжиж эхлээд 32 мянган малчин өндөр настны тэтгэвэрт гараад, дахиад нөгөө 300 хэдэн тэрбум төгрөг чинь дахиад 378 тэрбум төгрөг гээд ингээд бараг үндсэндээ бид нар чинь энэ малчдын яаж байгаа юу чинь 600 хэдэн тэрбум төгрөг шүү дээ. Одоо энэ чинь 600 хэдэн тэрбум чинь нийт манай нийгмийн даатгалын сангийн орлогын жилийн 15 хувь шүү дээ. 1.2 сая албан журмын шимтгэл төлж байгаа хүмүүсийн бүрдүүлж байгаа орлогын чинь 15 хувь байхгүй юу?

Тэгэхээр бид нар ингээд цаашдаа нэг ийм хууль батлах зөв үү, хэрэгжүүлэх шахах гэдэг зөв үү. Би хууль хэрэгжүүлэх гэдэгтэй бол тантай санал нэг байна. Тэгэхдээ би 2026 оны улсын төсөв дээр та бүхэн энэ хуулийг хэрэгжүүлэх эх үүсвэрийг нь тавьж өгөөч ээ. Тэгээд энэ хуулиа хэрэгжүүлээд одоо жишээ нь Энхбаяр сайд сууж байна. Малчдын хоршооны төсөл дээр чинь 5 их наяд. Энэ хүүгийн зөрүүг чинь төсөв дээр та тавиад явж байгаа шүү дээ. 1 их наяд нь гарчихсан

байгаа. Хүүгийн зөрүү бараг 2 зуугаад тэрбум билүү жилийн зуун тэрбум төгрөг тавиад явж байгаа шүү дээ. Яг энэнтэй адилхан тэгээд л тавиад л явъя. Малчдаа зүгээр дэмжээд. Тэгэхдээ өнөөдөр малчид дээр бид нар 50 хувийн нөгөө шимтгэлийг бид нар төлж байгаа шүү дээ төрөөс. Ийм одоо салбар байхгүй шүү дээ. Одоо ингээд 50 хувийг нь төлөхөд 2024 оноос хэрэгжиж эхэлсэн 50 хувийн НДШ-ийн төрөөс дааж байгаа энэ төсөл энэ хуулийг хэрэгжүүлж эхлэхэд 53800 малчин өнөөдөр улсын хэмжээнд төрөөс 50 хувийнхаа шимтгэлийг төлөөд явуулж байгаа байхгүй юу. Энд улсын төсвөөс 24 тэрбум төгрөг гарч байгаа. Улсын төсвөөс биш нийгмийн даатгалын сангаас бусдын төлсөн НДШ-ээс бид нар хумсалж байна л гэсэн үг байхгүй юу. Энийгээ л цөмөөрөө зөв тогтолцоонд оруулъя аа.

Үнэхээр эдийн засагт бол маш чухал салбар. Мэдээж 600 мянган хүн ажлын байр хангаж байгаа ийм салбар. Энэ дээр нийгмийн хамгааллын бодлого явах ёстой гэдэгтэй би тантай 100 хувь нэг байна.

Би хөдөөгөөс сонгогдсон гишүүн. Тэгээд ингээд би малчидтайгаа өдөр бүхэн уулзаж байгаа. Тэгээд энэ хуулиа хэрэгжүүлэх дээр Энхбаяр сайд тэгээд Тэмүүлэн дарга нар Аюулгүй байдлын байнгын хороод одоо хамтарч.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа.

Энх-Амгалан сайд би таныг уг нь шалтаг шалтгаан яриад бай гэж хэлээгүй. Эрх зүйт төрийн үндэс нь ерөөсөө хууль дээдлэх байдаг. Тэгээд хувь хүн биш хууль засагладаг төрийг бид нар яриад байгаа шүү. Тэгээд энийг та анхаарч ажиллаарай. Дараа дараадаа та улс төрд их олон жил байх байх. Хууль дээдлэх зарчмыг өөрөө хууль тогтоогч хүн та анхаарч ажиллаарай. Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалтыг явуулъя.

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон БНАУ хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшөөрч гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулна.

Гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалтыг явуулъя.

Санал хураалт 66.7 хувиар дэмжигдсэн.

Дээрээс нь төхөөрөмж ажиллаагүйгээс болоод Энхтүвшин гишүүн дэмжиж байна. Эрдэнэболд гишүүн дэмжиж байна. Алтаншагай гишүүн дэмжиж байна аа. Ингээд эдгээр 15 гишүүнээс 13 гишүүн дэмжсэн байна. Ингээд уг асуудлыг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэхээр байгаа.

Хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан байна. Идэвхтэй оролцсон ажлын хэсэг болоод гишүүдэд баярлалаа.

11.00 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА